



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

146 /146/

2021.09.30

ҮЙЛ ЯВДАЛ

МОНГОЛ УЛСЫН ТӨР, ЦЭРГИЙН ЗҮТГЭЛТЭН ХУРАНДАА ГЕНЕРАЛ Ж.ЁНДОНГИЙН ХӨШӨӨ НЭЭЛТЭЭ ХИЙВ



ХУРАНДАА ГЕНЕРАЛ Ж.ЁНДОНГИЙН ХӨШӨӨНИЙ НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЛ ЗУРГААС ...

ГЭРЭЛ ЗУРГИЙН ДЭСЛЭГЧ Н.ЭНКТОГТОХ

Монгол Улсын төр, цэргийн зүтгэлтэн, БХЯ-ны сайд, ЗХЖШ-ын дарга агсаны дурсгалын "Соёмбо" цогцолбор Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотноо сүндэрлэн бослоо. Тус хөшөө цогцолборын нээлтийн ёслолын ажиллагаа өнөөдөр 11:40 цагт зохион байгуулагдаж байгаа бөгөөд тус ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, УИХ-ын гишүүн Ж.Батсуурь, Сүхбаатар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга Д.Хосбаяр, Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат, ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, Батлан хамгаалахын сайд асан, дэслэгч генерал Л.Моломжамц, ҮБХИС-ийн захирал, бригадын генерал П.Жаргалан болон хурандаа генерал Ж.Ёндонгийн үр хүүхдүүд тус тус оролцож байгаа юм.

Монголын төр, цэргийн зүтгэлтэн, Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин, БНМАУ-ын БХЯ-ны сайд, БХЯ-ны нэгдүгээр орлогч бөгөөд Жанжин штабын дарга, Цэргийн Ерөнхий дээд сургуулийн захирал, Хүндэт харуулын анхны дарга зэрэг нэр хүндтэй бөгөөд хариуцлагатай албан тушаалуудад үүрэг гүйцэтгэж, олноо "Жагсаалч, рапорт Ёндон" хэмээн алдаршсан хурандаа генерал Ж.Ёндонгийн гавьяаг мөнхжүүлэн, алдаршуулах зорилгоор түүний төрсөн нутаг болох Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотноо "Хурандаа генерал Ж.Ёндонгийн дурсгалын хөшөө, цогцолбор"-ыг босгожээ. Энэхүү бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийг хандив, тусламжийн хэлбэрээр бүрдүүлсэн бөгөөд уг ажлыг эрчимжүүлэх зорилгоор Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний бие

бүрэлдэхүүнд хандаж гаргасан уриалгыг Зэвсэгт хүчний Жанжин штабын генерал, офицер, ахлагч нар манлайлан сэтгэлийн хандив өргөсөн юм. Энэхүү бүтээн байгуулалтын ажил нь Батлан хамгаалах яамны 110 жил болон Зэвсэгт хүчний 100 жилийн ойн хүрээнд хийгдэж байгаа ажлын нэг бөгөөд Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/98 дугаар тушаалаар Хурандаа генерал Ж.Ёндонгийн дурсгалын хөшөө, цогцолборыг байгуулах ажлыг удирдах ажлын хэсэг томилогдон өнгөрсөн хугацаанд уг дурсгалын хөшөө, цогцолборын зураг, бүүдүүвч, орчны тохижилтын зураг, тооцоо, шаардагдах хөрөнгийн төсөв, хөшөөний загварыг гаргаж, газрын асуудлыг нь бүрэн шийдвэрлүүлсэн юм. Уг дурсгалын хөшөө, цогцолборыг байгуулснаар төр, цэргийн нэрт зүтгэлтэн, хурандаа генерал

Ж.Ёндон агсны гавьяат үйлсийг сурталчлан мөнхжүүлэх, Сүхбаатар аймгийн төвийн өнгө үзэмж, тохижилтод хувь нэмэр оруулан орон нутгийн иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх амралт, зугаалгын орчныг бүрдүүлэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ахмад үеэрээ бахархах үзлээр хүүхэд, залуучуудыг хүмүүжүүлэхэд чиглэгдсэн төрөл бүрийн ажлыг тогтмол зохион байгуулах боломж бүрдэх зэрэг өндөр ач холбогдолтой юм. Мөн "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-т улс орныг батлан хамгаалах болон эх орныхоо бүтээн байгуулалтад гавьяат үйлсийг бүтээсэн төр, цэрэг, нийгмийн нэрт зүтгэлтнүүдийн баатарлаг, хөдөлмөрч үйл ажиллагааг залуу, хойч үеийнхэнд сурталчлах, тэднийг алдаршуулах, дурсгалын цогцолбор байгуулах зэрэг олон талт ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэхээр тусгажээ.

Түүхэнд энэ өдөр

1921 он:

Улаанбаатар хотын цэргийн хэлтэс байгуулагдав.

Их даргын сургууль хичээлээ эхэлжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
7	-7

ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
29	15

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,848.00	2,850.00
EUR	3,33.0	3,345.0
CNY	440.3	442.0
RUB	38.50	39.70
JPY	25.19	25.70
KRW	2.36	2.45

ЗУРХАЙ

2021.09.30 ПҮРЭВ ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 24/

НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САРЫН ТАВАН ШАР ЦАГААГЧИН МОГОЙ ӨДӨР
Үс засуулбал:
Өвчин эмгэг ирнэ
Наран ургах, шинжих:
06.50-18.34
Барилдлага:
Хотол чуулган
Шүтэн барилдлага:
Мунхрахуй
Суудал:
Шороо

Тухайн өдөр тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнес эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, сүм дуганыг сэргээх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, буг дарах, газрын ам бооход сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, өглөг тэжээх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одоосод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ


НИЙТ БҮРТГЭГДСЭН 295.886 +2515	ЭДГЭРСЭН 318.211 +6618	НАС БАРСАН 1185 +18
-----------------------------------	---------------------------	------------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 5257 +90	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 185	ЭДГЭРСЭН 4971
-----------------------------	----------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 234,057,967
Эдгэрсэн Нийт: 210,877,245
Нас барсан Нийт: 4,788,218



ҮЙЛ ЯВДАЛ

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУДЫГ ШАТ ДАРААТАЙ ШИЙДВЭРЛЭНЭ



Тус байгууллагын дарга, хурандаа С.Энхтайван байгууллынхаа танилцуулга болоод хийхээр төлөвлөж буй ажлынхаа талаар танилцууллаа. Үүнээс гадна тус байгууллагад тулгамдаад байгаа хэд хэдэн асуудлыг энэ үеэр хэлж байв. Тухайлбал, "Бөртэ" ТӨААТҮГ-ын барилга нь удаан жил болж байгаагаас шалтгаалан цахилгаан, дулааны шугамуудад хүндрэл үүссэн байна. Мөн түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалж "Бөртэ" цэргийн оёдлын үйлдвэрээс гарч буй бүтээгдэхүүний үнийг нэмэх зайлшгүй шаардлагатай байгааг дуулгав.

Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, БХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, хурандаа Б.Түвшинтөр нар өчигдөр БХЯ-ны харьяа "Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл", "Бөртэ" ТӨААТҮГ-уудад ажиллав.

Түүнчлэн өнгөрсөн сараас "Соёмбо" цэвэр ус нь ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд ингэснээрээ хэрэглэгчдээ эрхэмлэсэн чанартай бүтээгдэхүүнийг өдөр тутам хэрэглэх боломжийг бүрдүүлж байгаа ажээ.

"Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл" ТӨААТҮГ-т ажиллах явцад орлогч дарга, хурандаа Ө.Батмөнхийн танилцуулгыг сонсоны дараа "Соёмбо" цэвэр усны үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцав.

"Соёмбо" цэвэр ус нь үйлдвэрлэл явуулах стандартад нийцсэн тоног төхөөрөмжтэйгөөр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин болон 70 гаруй супермаркет, 10 гаруй аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллаж, стандартын шаардлага хангасан цэвэр усыг үйлдвэрлэж байгаа талаар танилцуулж байв.

Үүнийдараадэдсайд Б.Баярмагнай, хурандаа Б.Түвшинтөр нар "Бөртэ" ТӨААТҮГ-т ажиллав.



Г.К.ЖУКОВЫН ХӨШӨӨНД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Монгол Улс, ОХУ-ын хамтарсан "Сэлэнгэ-2021" байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургууль энэ сарын 22-ноос 10 дугаар сарын 5-ны өдрийг хүртэл хугацаанд үргэлжилж байна. Энэ хүрээнд хоёр орны цэргийн багийн удирдагчид болох Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр, ОХУ-ын Зэвсэгт хүчний Дорнод цэргийн тойргийн 36 дугаар армийн командлагчийн үүрэг гүйцэтгэгч, хошууч генерал И.Б.Тимофеев болон бусад албаны хүмүүс ЗХУ-ын дөрвөн удаагийн болон БНМАУ-ын баатар Г.К.Жуковын хөшөөнд

хүндэтгэл үзүүлэх ёслолын үйл ажиллагаа боллоо. Хошууч генерал И.Б.Тимофеевийн хэлснээр "Энэ жил манай хоёр орны найрамдалт харилцаа тогтсоны түүхт 100 жилийн ой тохиож байна. Өнөөдөр бид Дэлхийн хоёрдугаар дайны он жилүүдэд Монгол, Орос цэргүүдийг ялалтад хөтөлсөн түүхт жанжин, маршал Г.К.Жуковын хөшөөнд хүндэтгэл үзүүлж байна. Монголын ард түмэн энэ эрхэм хүний алдар, гавьяаг өнөөг хүртэл мөнхжүүлэн авч явж байгаад туйлын баяртай байгаагаа илэрхийлмээр байна" гэсэн юм.



ЦАХИМ ШУУДАНД

АЖИЛЛАГААНЫ ӨМНӨХ СУРГАЛТ БЭЛТГЭЛ ЭХЭЛЛЭЭ



БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын мандаттай энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Зэвсэгт хүчний XI ээлжийн мотобуудлагын батальоны ажиллагааны өмнөх сургалт бэлтгэлийг 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд амжилттай явуулж хүн нэг бүрийн бэлтгэл шатны сургалтыг дүүргэж салааны жигдрэлтийн шатны сургалт үргэлжилж байна.

Тус сургалтаар бие бүрэлдэхүүнийг мэргэжил,

албан тушаалын үүрэгт нь сурган дадлагажуулж, үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг ханган ажиллагааны газар оронд үүргээ мадаггүй биелүүлэх дадал, ур чадвар эзэмшүүлэхэд голлон анхаарч ажиллаж байна.

Энэ удаагийн ажиллагааны өмнөх бэлтгэл сургалт нь дэлхий нийтээр тархаж буй "Ковид-19" цар тахлын үед зохион байгуулагдаж байгаа хэдий ч Улсын онцгой комиссын болон Эрүүл мэндийн яамнаас гаргасан эрүүл ахуйн заавар, зөвлөмжийг өдөр бүр үйл ажиллагаандаа мөрдлөг болгон бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг хамгаалахад онцгой анхаарч халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажилласнаар онцлог байлаа.



ЭНЭ САРД ТӨРСӨН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

Батальоны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд ажиллагааны өмнөх бэлтгэлийн үед бие бүрэлдэхүүний чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, сэтгэл санааны тогтвортой байдлыг хангах зорилгоор 9 дүгээр сард төрсөн 57 цэргийн алба хаагчдын төрсөн өдрийг тэмдэглэв.

Энэ хүрээнд алба хаагчдыг тусгай штабаас гаргасан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хүндэтгэл үзүүлж, урлагийн хэсэгчилсэн тоглолтыг толилуулан төрсөн өдрийн мэндчилгээ дэвшүүллээ.

Уг арга хэмжээнд мотобуудлагын батальоны захирагч, хурандаа О.Заяат төрсөн өдрөө тэмдэглэж буй цэргийн алба хаагчдад эрүүл энхийг хүсэн ажиллагааны өмнөх сургалтад амжилт хүслээ. Төрсөн өдрийн баярт зориулж салбаруудаас ая дууны мэндчилгээ дэвшүүлж, халуун баярыг хүргэсэн нь онцлог үйл явдал байлаа.

Ахлах дэслэгч Ц.БАДАМСҮРЭН



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ

- Батлан хамгаалах яам
- Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС

- "Соёмбо" сонин
- "Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)